



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/101

Зуунмод

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан шилжих үлдэгдлийн эх үүсвэрээс хэрэгжүүлэх “Сум, төсөвт байгууллагуудын автомашины парк шинэчлэлд орон нутгийн оролцоо (10 автомашин) төсөл, арга хэмжээнээс хавсралтад дурьдагдсан Бүрэн, Лүн, Эрдэнэ, Борнуур сумдын автомашины худалдан авах ажиллагааг зохион байгуулах, захиалагчийн эрхийг холбогдох сумдын Засаг дарга нарт шилжүүлсүгэй.

2. Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр шуурхай зохион байгуулж, тендерийн урилга, төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил, үр дүн, гэрээ, ажил хүлээж авсан актыг тухай бүр цахим системд нийтэлж байхыг сумын Засаг дарга, захиалагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар  
сарын 19 -ны өдрийн А/101 дүгээр  
захирамжийн хавсралт

ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөв /аймаг/	Сумаас нэмэгдсэн төсөв	Нийт өртөг /төгрөг/	Захиалагч байгууллага
1	Сум, төсөвт байгууллагуудын автомашины парк шинэчлэлд орон нутгийн оролцоо /Бүрэн сум/	40,000,000	30,000,000	70,000,000	Бүрэн сумын Засаг дарга
2	Сум, төсөвт байгууллагуудын автомашины парк шинэчлэлд орон нутгийн оролцоо /Лүн сум/	40,000,000	50,000,000	90,000,000	Лүн сумын Засаг дарга
3	Сум, төсөвт байгууллагуудын автомашины парк шинэчлэлд орон нутгийн оролцоо /Эрдэнэ сум/	40,000,000	40,000,000	80,000,000	Эрдэнэ сумын Засаг дарга
4	Сум, төсөвт байгууллагуудын автомашины парк шинэчлэлд орон нутгийн оролцоо /Борнуур сум/	40,000,000	-	40,000,000	Борнуур сумын Засаг дарга
	ДҮН	160,000,000	120,000,000	280,000,000	